

## Аймгийн эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх зорилт

### **Нэг. Ажилтай, орлоготой Монгол хүн**

1. Санхүүгийн тайлангийн 65%-иас доошгүйг цахимаар авч, төсөвт болон аж ахуйн нэгж, байгууллагуудыг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болгох ажлыг зохион байгуулна
2. Хөндлөнгийн мэдээллийн дагуу хийх татварын ногдуулалтыг нэмэгдүүлж, хураалтыг сайжруулан татвар төлөгчдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх, татварын цахим мэдээллийн системд шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна
3. Төрийн сангийн дотоод хяналт, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, төсвийн зарцуулалт, үр ашгийг дээшлүүлэн, төсвийн аливаа хуримтлагдсан өр авлага үүсгэхгүй ажиллана
4. Шилэн халаас хөтөлбөрийн хүрээнд “Төсвийн ил тод байдал” уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, төсвийн сахилга батыг чангатган, хөндлөнгийн хяналт үнэлгээг хийж, төрийн байгууллагуудын харилцах дансыг ил тод, нээлттэй болгоно
5. Тэргүүн ээлжинд дэмжих жижиг дунд үйлдвэр, бизнесийн чиглэлийг олон түмэнд нээлттэй зарлах, Увс түншлэл, хилийн худалдаа, цагаан сар үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, олон улс, улс, бүсийн хэмжээнд зохиогдсон үзэсгэлэн, арга хэмжээнд иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулна
6. Мэргэжлийн салбар холбоод, хувийн хэвшлийнхний уялдаа холбоог сайжруулан, төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлж, дэмжиж ажиллана
7. Хөөсөнцөр хавтан, сэндвич, хөнгөн блок, хайрга чулууны карьер, бетон зуурмагийн зэрэг барилгын материалын үйлдвэр, давс боловсруулах цех байгуулах, утаагүй, шахмал түлш үйлдвэрлэхийг дэмжинэ
8. 1000 айлын орон сууцны хороолол, Улиасны хэвд байгуулагдах 200 айлын загвар хорооллын гадна дулаан, цэвэр, бохир усны шугам, цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, 400 айлын жишиг хорооллыг барьж эхлүүлнэ
9. Шинэ дулааны станцын барилга угсралтын ажил, гадна дулааны шугам сүлжээ, дулаан дамжуулах төвийн ажлыг дуусган хүлээн авч, дулаан дамжуулах төвөөс хэрэглэгч хүртэлх инженерийн шугамуудыг ашиглалтанд оруулна
10. Номын сангийн арын замаас 1-р цогцолбор сургууль хүртэл, “Чандманы автобусны 1-р буудлаас-Өрхийн эмнэлэг-Чандмань Эрдэм сургууль-Хүрт хоршоо”-г төв замтай холбох чиглэлд хатуу хучилттай авто зам барина
11. Цанын бааз, хог боловсруулах үйлдвэрийн төлөвлөгдсөн газар, Увс нуурын дэргэдэх аялал жуулчлалын гэр бааз, хурдан морины уралдааны газрын чиглэлд цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, тохижилт хийнэ
12. Номын сангийн арын замаас 1-р цогцолбор сургууль хүртэл, Буянт хорооллоос-Улиасны хэвийн чиглэлд авто зам дагуу гудамжны гэрэлтүүлэг хийнэ
13. Сумын төвүүдийн төрийн байгууллагуудыг нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох ажлыг судлаж, ээлж дараатай шийдвэрлэнэ
14. Улаангом сумын 1, 2-р 48, 1-р 60 айлын орон сууцны зоорийн давхрын, Нефть, Гаалийн орон сууцны гадна дулаан, хэрэгцээний халуун ус, цэвэр, бохир усны шугамыг шинэчлэн, 4-р цэцэрлэгийн барилгын гадна дулаан, цэвэр усны шугамыг өргөтгөнө
15. Улаангом сумын ахлах 3-р сургууль, 4-р сургууль, татварын хэлтсийн гадна авто машины зогсоол хийж, хотын доторх хатуу хучилттай замд нөхөөс, замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч хийнэ

- 16.Худалдааны гудамжны явган замыг үргэлжлүүлж, төв замаас Нийгмийн халамж үйлчилгээний төв болон 1-р цэцэрлэг хүртэл сайжруулсан шороон зам тавина
- 17.Газар тариалан, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ үйлдвэрлэгч өрх, фермер, хоршооллын аж ахуйг техник тоног төхөөрөмжөөр хангах, боловсруулах үйлдвэрлэл, цех байгуулахад нь дэмжлэг үзүүлнэ
- 18.Сумуудад бэлчээрийн хортон мэрэгч, үлийн цагаан оготны тархалтын судалгаа гаргаж, устгал хийнэ
- 19.Газар тариалангийн салбарт үрийн шинэчлэл хийж, 7,5 мянган га-д үр тариа, 240 га-д төмс, 190 га-д хүнсний ногоо тариалж, 5000 га-д уринш хийж, тариалалтын ажлыг технологийн хугацаанд нь хийнэ
- 20.Байгаль цаг уурын хуурайшилттай үед таримал ургамлын соёололт, бутлалтын хугацаанд үүлэнд зориудаар нөлөөлж, хур тунадас оруулах арга хэмжээ авна
- 21.Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2026.0 мянган толгой, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 700.0 мянган толгой, бруцеллюз өвчний тандах шинжилгээнд 19.0 мянган толгой малыг хамруулах ажлыг зохион байгуулна
- 22.Мал сүрэгт ангилалт, ээмэгжүүлэлт, бүртгэлжүүлэлт хийж, үржлийн хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан зах зээлд борлуулж, үржлийн малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулна
- 23.Улаангом болон бусад сумдын төвийн орчинд мал түүхий эдийн төрөлжсөн зах, мах, сүүний чиглэлийн үхэр, гахайн фермерийн аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр цех байгуулахад дэмжлэг үзүүлнэ
- 24.Өвлийн хүлэмж байгуулахыг бодлогоор дэмжин, хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллана
- 25.2-р 64 айлын орон сууцны өмнөх гражийг чөлөөлж дулаан граж, хүүхдийн тоглоомын талбайг барьж, орон сууцны хорооллын дундах зам, талбайд тохижилт хийнэ
- 26.Төсвийн байгууллагуудын аж ахуй, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлнэ
- 27.Давст, Сагил, Баруунтуруун, Өндөрхангай, Өлгий, Ховд, Өмнөговь сумдын ахмадын байр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны засвар хийнэ.
- 28.Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрах хүрээг өргөжүүлж, эдийн засгийн идэвхтэй хүн амын 29 хувьд хүргэнэ.
- 29.Ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн иргэдийг ажлын байранд зуучлах замаар 1000-аас доошгүй ажлын байрыг шинээр бий болгож, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдээс тухайн жилд хамгийн олон байнгын ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, иргэнийг урамшуулж, бодлогоор дэмжиж ажиллана
- 30.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулсан аж ахуй нэгж байгууллагыг шагнаж урамшуулан олон нийтэд сурталчлах, туршлага солилцох сургалт зохион байгуулна
- 31.Хувиараа хөдөлмөр эрхэлдэг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зах зээлд байр сууриа эзлэхэд дэмжиж, хэрэгцээт болон дохионы хэлний сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна
- 32.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих нөхцлийг бүрдүүлнэ
- 33.Нийгмийн халамжийн санг төлөвлөх, зарцуулах эрхийг сумуудад шилжүүлж, амьжиргааны түвшний судалгааны мэдээллийн санг үндэслэн нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэдийг хэрэгцээт үйлчилгээнд нь хамруулна
- 34.Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн хүрээнд аялал жуулчлалын бааз байгуулах боломжит газруудыг нийтэд зарлан сурталчилж, хувийн хэвшилд түшиглэсэн аялал жуулчлалын бааз байгуулахыг бодлогоор дэмжинэ

35. Аймгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг сайжруулж, аймаг, суманд хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын үр өгөөжийг дээшлүүлж, хөгжлийн нэгдсэн бодлоготой уялдуулна
36. Зочид буудал, зоогийн газар, худалдаа үйлчилгээний байгууллагуудын үйлчилгээний чанар, стандарт, эрүүл ахуйн орчныг сайжруулан бодлогоор дэмжиж ажиллана
37. Газрын нэгдсэн сангийн “Ланд менежер” программыг нэвтрүүлж, газрын харилцаа, геодези, зураг зүйн мэдээллийн нэгдсэн санд холбогдож газар олголт, төлөвлөлтийг нэгдсэн бодлогоор хангана
38. Ханхөхий, Хяргас нуурын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргааны барилга, байгаль хамгаалагчийн нэг загварын байрыг барина
39. Тэсийн голын 127 у/м төмөр бетон гүүрийн ажлыг үргэлжлүүлж, Сагилийн гүүрнээс сумын төв хүртэл хайрган хучилттай зам барина
40. Цагаанхайрхан сумын Хунт, Хулж баг, Завхан сумын “Хэцүү хад” жуулчны баазад цахилгаан дамжуулах агаарын шугам барина

### **Хоёр. Эрүүл чийрэг Монгол хүн**

1. Хяргас, Ховд, Зүүнхангай сумын эрүүл мэндийн төв, Тэс сумын Таван улиас багийн эмнэлэг, Сагил сумын эхчүүдийн амрах байрны барилгад засвар хийж, иргэдэд үйлчлэх халамжийн төвийн барилгын гадна шугам, сүлжээний холболтын ажлыг хийнэ
2. Нэгдсэн эмнэлгийг дотоод сүлжээнд холбож, Бөхмөрөн, Өндөрхангай, Баруунтуруун, Давст сумын түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийнэ
3. Сум дундын эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвүүдийг нөхөн үржихүйн загвар эмнэлэг болгох ажлыг эхлүүлнэ
4. Эрүүл мэндийн салбарын гадаад, дотоод харилцааг өргөжүүлэн эмч мэргэжилтнүүдийг төрөлжсөн болон үндсэн мэргэжлээр гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулна
5. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэн, иргэд чөлөөт цагаараа амрах, дасгал хөдөлгөөн хийхэд зориулагдсан биеийн тамирын ил талбай байгуулна
6. Улсын аварга шалгаруулах цана, жүдо бөхийн, спортын 15 төрлөөр аймгийн “Бага олимп”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн параолимп”, аймгийн Засаг даргын нэрэмжит бөхийн төрлүүдийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж спортын холбоодыг дэмжин хамтарч ажиллана
7. Бөхийн өргөөнд “Бөхийн хүндэтгэлийн танхим”-ыг тохижуулж, аймгийн спорт заал, бөхийн танхимын барилгад засвар хийнэ

### **Гурав. Эрдэм боловсролтой Монгол хүн**

1. Сургууль, цэцэрлэгийг сонгодог урлагийн хөгжим, биеийн тамирын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж материаллаг орчинг сайжруулна
2. Боловсролын шинэчлэлд бүх шатны удирдлага, хүүхэд, багш, эцэг эх, дэмжигч байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ
3. “Авьяс” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд бүрийн авьяасыг илрүүлэн хөгжүүлж, мэдлэг хандлагыг нь өөрчлөх уралдаан тэмцээн зохион байгуулж шалгарсан бүтээл, бүтээгдэхүүнийг сурталчилна
4. “Ном” хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, эцэг эх, багшийн бүтээлүүдийг ном болгон хэвлүүлж, номын худалдааг дэмжин, номын сангуудын номын фондыг нэмэгдүүлэн, “Номын сайн нөхөр” аяныг зохион байгуулна
5. Баруун Монголын уламжлалт соёлын төвийн барилгын ажлыг дуусгаж, “Ойрад” хөгжимт жүжгийн театр, Соёл, спорт, аялал жуулчлалын газрыг өсгөгч, уэльс, техник хэрэгслээр хангана
6. Хүүхдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хөдөлмөр амралтын зуслан, эко аялал, хөрш зэргэлдээ улсуудад амруулах ажлыг зохион байгуулна
7. Тариалан сумын ахлах сургууль, Өмнөговь сумын цэцэрлэг, Малчин сумын сургуулийн дотуур байрны барилгыг ашиглалтанд оруулж, Зүүнхангай сумын сургуулийн дотуур

байр, цэцэрлэгийн барилгад засвар, Улаангом сумын 3-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын зураг төсөв хийх, Чандмань-Эрдэм ахлах сургуулийн барилгын өргөтгөлийн ажлыг эхлүүлж, Тэс, Тариалан, Наранбулаг, Зүүнхангай сумын сургуулийн дотуур байрны, Улаангом сумын 2-р цэцэрлэгийн халаалтын зуухыг шинэчилнэ.

8. Элсэлтийн ерөнхий шалгалтанд 600-аас дээш оноо авч Ховд их сургуульд багшийн мэргэжлээр элссэн оюутнуудад дотуур байрны төлбөрийн хөнгөлөлт, бүтэн өнчин хүүхдүүдэд дэмжлэг үзүүлнэ
9. Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын шилдэг техник технологи, тэргүүн туршлага, мэдээ мэдээллийг олж авах нөхцлийг бүрдүүлж, иргэдийн гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор гадаад хэлний сургалтуудыг зохион байгуулна
10. Аймгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгцээт мэргэжлийн судалгааг гаргаж их, дээд сургуульд элсэгчдэд зөвлөгөө өгөх, эрэлттэй мэргэжилтэн бэлтгэх бодлогыг хэрэгжүүлнэ
11. “Залуучуудын хөгжлийн төв”-ийг байгуулж, залуучууд, оюутнуудын хөгжлийг бодлогоор дэмжин ажиллана

### ***Дөрөв. Аюулгүй орчинтой Монгол хүн***

1. “Архигүй Монгол” хөтөлбөрийг хэрэгжүүлэн аймгийн зах орчмын нутаг дэвсгэрт “Иргэдэд үйлчлэх цагдаагийн хэсэг”-т шаардлагатай техник хэрэгслээр хангаж, Цагдаагийн газрыг “согтуурал хэмжигч багаж”-аар хангана
2. “Авлигын эсрэг” хөтөлбөрийг боловсруулан баталж хэрэгжүүлнэ
3. Улаангом сумын төв зам, гудамж талбай, авто машины зогсоол, пост болон хүн амын нягтрал, хөдөлгөөн ихтэй газруудад “Төрийн үйлчилгээний хяналтын нэгдсэн систем”-ийг суурилуулах ажлын зураг төсвийг хийнэ
4. Ойжуулалтын ажлыг 50 га, ойн туслах зурвас байгуулах ажлыг 60 га, ойн хортны устгалыг 100 га талбайд хийж, түлшинд хожуул хэрэглэх журмыг боловсруулан хэрэгжүүлж ажиллана
5. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, 10 булаг шандын эхийг хамгаалан тохижуулж, хөв цөөрөм нэгийг байгуулж бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ
6. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжинэ
7. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн аймгийн зөвлөгөөн зохион байгуулж, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлтийг 10 га-д хийнэ
8. Малчид, иргэдэд өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх “Иргэний үүргийн даалгавар”-ын биелэлтийг хангуулж, аймгийн аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийн хэмжээг нэмэгдүүлж, Өндөрхангай суманд өвс, тэжээлийн агуулах барина
9. Төв цэвэрлэх байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, шинэчлэх ажлыг эхлүүлнэ
10. Төв суурин газрын гэр хорооллын ундны усны худгуудад шинжилгээ хийж, шүүлтүүр тавих ажлыг дэмжинэ.
11. Увс нуур-Тэс голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулан батлуулж, сав газрын захиргааг албан ажлын байраар хангана
12. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд, иргэдийг хамгаалах төв ажиллуулна
13. Орон гэргүй хүмүүст гэр олгох ажлыг зохион байгуулж, гэржүүлэх бодлого хэрэгжүүлнэ
14. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байр барих, Төрийн архивын байрны зураг төсөв хийнэ
15. Нэгдсэн эмнэлэгт аюултай хог хаягдлыг түр хадгалах байр барьж, сум, аймгийн төвийн хур хогийг цэвэрлэнэ

### ***Тав. Эрх чөлөөтэй Монгол хүн***

1. “Том төрөөс Ухаалаг төр” үндэсний зөвлөгөөний зөвлөмжийг төрийн байгууллагуудад хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний цахим машиныг ажиллуулна

2. “Шинэ Улаангом” хотын дахин төлөвлөлтийг хийж “Гудамж төсөл”-ийг хэрэгжүүлэн, Баруунтуруун, Бөхмөрөн, Завхан, Зүүнхангай, Малчин, Өндөрхангай, Тэс, Ховд, Хяргас, Цагаанхайрхан сумдын төвийг тохижуулна
3. Шинэчлэлийн Засгийн газрын “Жишиг сум” хөтөлбөрт Тэс сумыг хамруулан тохижуулна
4. “Өрхтэй харилцах дэвтэр”-ийг шинээр нээж, төр иргэний харилцааг эрхэмлэн, төрийн үйлчилгээг өрх бүрт хүргэнэ
5. Өлгий, Хяргас сумдын ЗДТГ-ын барилгад засвар хийнэ
6. Төрийн байгууллагууд иргэний танхим, хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагааныхаа үр дүнг иргэдэд тайлагнаж хэлэлцүүлэх, иргэдээс гарсан саналыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж, үр дүнг мэдээлэх ажлыг хэвшүүлнэ
7. Засаг даргын дэргэдэх “Иргэний зөвлөл”-өөс хэлтэс, агентлагийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж үр дүнг бодлого шийдвэр, үйл ажиллагаандаа тусгаж олон нийтэд мэдээлнэ
8. 70452222.mn цахим үйлчилгээг өргөтгөж өргөдөл гомдол, санал хүсэлтийн шийдвэрлэлт, сум, хэлтэс, агентлаг, иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл гомдлын мэдээг цахим хаягаар нэгтгэн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана
9. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, орчин нөхцлийг сайжруулах зорилгоор Улаангом суманд багийн цогцолбор төвийг барьж, хөдөөгийн багийн төвүүдийг ээлж дараатай засварлан тохижуулна
10. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх богино хугацаат төрөлжсөн сургалтуудыг онол, дадлага хосолсон хэлбэрээр зохион байгуулна
11. Төрийн байгууллагын үйлчилгээнд ISO-д суурилсан чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ
12. Хөрш зэргэлдээ ОХУ-ын муж улс, БНХАУ-ын ШУӨЗО-ны аймгуудтай тогтоосон харилцааг гүнзгийрүүлж, дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудтай харилцаа тогтоож оюутан залуусыг гадаадын их дээд сургуульд солилцон сургах, бизнес эрхлэгчдийг олон улсын форум, үзэсгэлэн худалдаанд оролцуулах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ
13. Сумдыг шилэн кабельд холбох, интернет, кабелийн үйлчилгээний чанар, ашиглалтыг сайжруулж, мэдээ мэдээллийн шуурхай, ил тод байдлыг хангаж ажиллана
14. Иргэдэд мэдээллийг шуурхай түгээх боломж, сувгийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжид хэрэглэгчийн үнэлгээ өгөх, олон нийтийн эрх ашгийг судлан тодорхойлох зорилго бүхий мэдээлэл, технологийн мобигэйдэр үйлчилгээг нэвтрүүлнэ
15. Хууль сурталчлах, хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Хууль дүрэм бодит амьдралд” аяныг зохион байгуулна
16. Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, Өлгий сумын ЗДТГ-ын авто машиныг шинэчлэнэ
17. Улаанбаатар хотод “Увсын өдрүүд” арга хэмжээг зохион байгуулна
18. Аймгийн 90 жилийн ойг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан, “Увс аймгийн түүх”-ийн эрдэм шинжилгээ, судалгааны 5 боть номыг бэлтгэнэ